

**“ХАСУ-МАНДАЛ” ХК-ИЙН  
2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хасу-Мандал ХК нь 1997 оноос өмнө барилга угсралт ойн аж ахуй мод бэлтгэх, зүсмэл модон материалын үйлдвэрлэл эрхэлж байсан хэдий ч орчин үеийн техник технологи, стандартын дагуу үйл ажиллагаа явуулахад хүндрэл гарсан тул үйлдвэрлэлээ зогсоож Худалдаа үйлчилгээний төв байгуулж өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулсаар байна.

Манай компанийн тус нийтийн худалдааны төв нь 2013 онд засвар шинэчлэл хийж хүнс бараа, гэр ахуйн болон бусад бараа бүтээгдэхүүний худалдааны чиглэлээр 400 гаруй худалдаа эрхлэгчидтэй үйл ажиллагаа явуулж байгаад 2016 оноос зах зээл, эдийн засгийн өөрчлөлтөөс тус тоо буурч одоогоор 200 гаруй хамтрагчтай үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

Худалдаа эрхлэгчдийн тогтвор суурьшилтай ажиллах, тэднийг идэвхжүүлэх, урамшуулах чиглэлээр нийгмийн хариуцлагынхаа хүрээнд жил бүр шинэ жилийн цэнгүүний арга хэмжээ, цасны баяр, сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннисний тэмцээн зэрэг арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулан ажилладаг.

**Хасу-Мандал ХК-ний 2019 онд хийсэн ажлын жагсаалт:**

1. Архангай аймгийн замын цагдаагийн тасагтай хамтран өөрийн хөрөнгөөр авто машины зогсоолын тусгаарлан тэмдэг тэмдэглэгээ хийж, хаалтыг шинэчилсэн
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад нийт ажилчдыг хамруулсан
3. Сонгогдсон ажилчдыг мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулсан
4. Монгол улсын донорын өдрийг тохиолдуулан хүндэт доноруудыг хүлээн авч гарын бэлэг, бусад зүйлээр урамшуулсан
5. Байгууллагаас өндөр настны тэтгэвэрт гарсан жил бүрийн цагаан сар, өндөр настны баяраар хүлээн авч, гарын бэлэг өгч урамшуулдаг
6. Нийт ажилчид түрээслэгч нарт Гэр бүл, хүүхэд хөгжлийн газартай хамтран эрүүл ахуй, хүүхдийн хүчирхийлэл, стандартын талаар сургалт явуулсан

**Урсгал засварын ажил:**

Үүнд:

- 1-4 давхарын 150 м агааржуулалтын хоолойг нэмэлтээр суурилуулсан
- Хүнс барааны захын гадна дотор хаалгыг бүрэн шинэчилсэн
- 1/0 м<sup>2</sup> гадна талбайг бүрэн цементлэн тохижуулсан
- Дээврийн ажлыг дахин хийж засварласан
- Сэлбэг, гэр ахуйн худалдааны төвийн гадна талбайн камерт шинэчлэл хийж сайжруулсан